МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.10.14 № 70

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

Бүтэн өнчин хүүхдийн бүртгэл, асран хамгаалалт, хүүхдийн эрхийн хамгааллын хэрэгжилтийн талаар

Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолын 1 дэх заалтын 3/а хэсэгт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хяналтын механизмыг сайжруулах, тэтгэмжийн сан, тусгайлсан бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх; 3/б хэсэгт асрамж, халамжийн төвөөс насанд хүрч гарсан өнчин хүүхдийн боловсрол эзэмшихэд үзүүлэх дэмжлэг, хөдөлмөр эрхлэх, орон байрны асуудлыг шийдвэрлэхийг Засгийн газарт даалгаж, хэрэгжилтийг 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хороонд танилцуулахаар тогтоосон. Мөн Хүүхэд хамгаллын тухай хуулийн 48 дугаар зүйлд хүүхэд хамгаллын мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн цахим хувийн хэргийг хуульчилсан.

Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд 2022 онд улсын хэмжээнд 2,911 бүтэн өнчин хүүхэд бүртгэгдсэнээс 204 нь асрамж, халамжийн төвд бүртгэлтэй тухай дурджээ. Асрамж, халамжийн төвийн бүртгэлээс гадуур байгаа бусад 2,707 хүүхдийн асран хамгаалалтын хэлбэр, хууль ёсны асран хамгаалагч, амьдрах нөхцөл, эрхийн хамгаалал, хяналтын бодит байдлын талаарх мэдээллийг тодруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.13, 37.1.2, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг тавьж байна.

1.2022 онд асрамж, халамжийн төвөөс гадуур бүртгэгдсэн 2,707 бүтэн өнчин хүүхдийн мэдээллийг улсын бүртгэл, хүүхэд хамгаалал, нийгмийн хамгааллын мэдээлэлтэй хүүхэд тус бүрээр баталгаажуулсан эсэх, 2026 оны 9 дүгээр сарын байдлаар насанд хүрсэн, үрчлэгдсэн, нас барсан, асрамжийн хэлбэр өөрчлөгдсөн болон бусад тохиолдлуудыг баталгаажсан, баталгаажуулаагүй, давхардсан, зөрүүтэй бүртгэгдсэн зэргээр ангилсан дэлгэрэнгүй тоон мэдээлэл, эдгээрийн шалтгааны талаарх тайлбар;

2.2022–2025 оны жилийн эцэс болон 2026 оны 9 дүгээр сарын байдлаарх бүтэн өнчин хүүхдийн тоог аймаг, дүүрэг, нас, хүйс, амьдарч буй орчин, асран хамгааллын хэлбэрээр ангилсан мэдээлэл, гэр бүл, төрөл садны асрамж, асрамж, халамжийн төв болон бусад хэлбэрийн бүртгэлийн хамралт, мэдээллийн эх сурвалж, байгууллага хоорондын зөрүү, түүнийг арилгасан үр дүнгийн талаарх мэдээлэл;

2026000206

3.Хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилсон шийдвэртэй болон шийдвэргүй, баталгаажаагүй хүүхдийн тоо, шалтгаан, 2024–2026 онд гэр бүл, төрөл садны орчинд амьдарч буй хүүхдэд хийсэн гэрийн эргэлт, эрсдэлийн үнэлгээ, давтан хяналтын давтамж, хамрагдалт, илэрсэн эрсдэл, зөрчил, авсан хамгаалалтын арга хэмжээ, шийдвэрлэсэн ба шийдвэрлээгүй тохиолдлын тоог аймаг, дүүргээр гаргасан судалгаа, мэдээлэл;

4.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 48.1–48.4 дэх хэсгийн хэрэгжилт, мэдээллийн сан, цахим хувийн хэрэг ашиглалтад орсон огноо, хамрагдсан бүтэн өнчин хүүхдийн тоо, нийт бүртгэлд эзлэх хувь, Засгийн газрын баталсан журам, холбогдох шийдвэрийн хуулбар, өгөгдлийг шинэчлэх давтамж, давхардал болон зөрүүг илрүүлж засах механизм, улсын бүртгэл, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагуудтай мэдээлэл солилцох бодит үр дүн, хувийн мэдээллийг хамгаалах арга хэмжээний талаарх мэдээлэл;

5.2024–2026 онд боловсрол, эрүүл мэнд, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан болон эрхтэй боловч хамрагдаагүй бүтэн өнчин хүүхдийн тоо, шалтгаан, нөхөн олгосон буюу шийдвэрлэсэн үр дүн, хүчирхийлэл, үл хайхрах байдал, тэтгэвэр, тэтгэмжийн зориулалтын бус зарцуулалт, өвлөх болон өмчлөх эрхийн зөрчлийн талаарх бүртгэгдсэн, шалгасан, шийдвэрлэсэн болон шийдвэрлэгдээгүй тохиолдлын тоон мэдээлэл;

6.Тогтоолын 1 дэх заалтын 3/а, 3/б хэсэгт заасан арга хэмжээ тус бүрийн хариуцагч байгууллага, батлагдсан шийдвэр, хэрэгжилтийн явц, түвшин, зарцуулсан төсөв, хэмжигдэхүйц үр дүн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн амьжиргааг дэмжих сан, тэтгэвэр, тэтгэмжид гарсан өөрчлөлт, тусгайлсан бодлогын хэрэгжилт, асрамж, халамжийн төвөөс насанд хүрч гарсан өнчин хүүхдэд боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, орон байртай болоход үзүүлсэн дэмжлэгийн хамрагдалт, үр дүнгийн талаарх мэдээллийг 2025 оны хаврын чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан эсэх, танилцуулаагүй бол шалтгааны талаар тайлбар;

7.Дээрх асуултуудад дурдсан бүртгэл, хууль ёсны асран хамгаалалт, хүүхдийн амьдрах орчны хяналт, хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сангийн хэрэгжилттэй холбоотой шийдвэрлэгдээгүй асуудлыг шалтгаан, эрсдэлийн түвшин, шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээгээр ангилсан мэдээлэл; эдгээр асуудлыг шийдвэрлэхэд 2024–2026 онд зарцуулсан төсөв, 2027 онд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээ, зориулалтын задаргаа; асуудал тус бүрийг шийдвэрлэх хариуцагч байгууллага, гүйцэтгэх хугацаа, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжилтэд тавих хяналтын механизмын талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАЯРМАА

2026000206